



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Б.Ширэндэвийн гудамж 8/4, Засгийн газрын V байр,  
Утас/Факс: (976-51) 26 75 33, И-мэйл: foreign@mojha.gov.mn,  
Вэбсайт: www.mojha.gov.mn

2020.07.24 № 1-1118  
танай 2020.07.05-ны № 01/55001-т

Г ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
САЙД Л.ХАЛТАР ТАНАА

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/123 дугаар тушаалыг Захиргааны өрөнхий хууль болон холбогдох бусад хуулийн дагуу хянан үзэж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 3968 дугаарт бүртгэлтэй Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны “Журам шинэчлэн батлах тухай” 131 дүгээр тушаалд холбогдох хөдөлгөөн хийснийг мэдэгдье.



151600092  
Doc.yam a5.2020



Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн санд  
2020. оны 07. сарын 27-ны  
өдөр хүлээн авсан.

МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
САЙДЫН ТУШААЛ

2020 оны 07 сарын 01 өдөр

Дугаар A/123

Улаанбаатар хот


Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг,  
Авто замын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дэх заалтыг тус тус үндэслэн  
ТУШААХ нь:


- Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 131 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Авто зам, замын байгууламжийн техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлын тусгай зөвшөөрөл олгох журам"-ын 2.8.2.1 дэх хэсэгт "2.8.2.1.1 5 км хүртэл хатуу хучилттай зам барих, 2.8.2.1.2 5 км-ээс 15 км хүртэл хатуу хучилттай зам барих, 2.8.2.1.3 15 км болон түүнээс дээш хатуу хучилттай зам барих" гэж тус тус нэмсүгэй.
- Тусгай зөвшөөрлийн ангилал өөрчлөгдсөнтэй холбогдуулан "Тусгай зөвшөөрөл олгох ажлын төрөл, нөхцөл, шаардлага"-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
- Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /М.Энхболд/-т даалгасугай.

САЙД

Б.ЭНХ-АМГАЛАН



Зам, тээврийн хөгжлийн сайдын  
2020 оны 07 дугаар сарын 01-ны өдрийн  
АМС тоот тушаалтын хавсралт



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖЛЫН ТӨРӨЛ, НӨХЦӨЛ, ШААРДЛАГА

УЛААНБААТАР ХОТ  
2020

Бүртгэлийн дугаар 400  
МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ  
ХУУЛБАР ҮНЭН  
Хуулбар олгосон тийтийн гарын усог  
Ом  
2020 оны 07 сарын 16-ний одор

НЭГ. Техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах, авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд:

Нийтлэг нөхцөл шаардлагыг хангахаас гадна дараах шаардлагыг хангасан байна.

Ажилбар	Шаардлагатай инженер-техникийн ажилтан	Шалгуур үзүүлэлт
2.8.1.1. Техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах	Авто замын инженер-2	Аль нэг авто замын инженер нь мэргэжлээрээ 10-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 8 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, Зөвлөх зэрэгтэй байх шаардлагатай. /З-с дээшгүй аж ахуйн нэгжид гэрээт байж болно/
	Гүүрийн инженер-1	Тухайн мэргэжлээрээ 10-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 6 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, Зөвлөх болон мэргэшсэн зэрэгтэй байх шаардлагатай.
	Геодезийн инженер-1	Тухайн мэргэжлээрээ 5 жилийн ажлын туршлагатай үүнээс 3 жилд нь замын зураг төсөл дээр геодезийн инженерээр ажилласан байх шаардлагатай. Хэмжилтийн багажнуудыг чадварлаг эзэмшдэг байх. GPS болон топографын судалгаа, түүнтэй холбоотой программ хангамжийг мэргэжлийн тувшинд ашиглаж чаддаг байх.
	Инженер-эдийн засагч-1	Тухайн мэргэжлээрээ 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 3 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх. Мөн замын зураг төслийн ажилд төсөвчнөөр ажилласан байх. /Энэ чиглэлээр 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай авто замын инженер байж болно/
2.8.1.2. Төв замын зураг төсөл боловсруулах /Замын байгууламжид 30 у/м-ээс ихгүй гүүр, гүүрэн гарц, усны хоолой, авто замын хөдөлгөөнд зориулсан газар доогуурх гарц, хонгил, ус зайлцуулах шуудуу, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зориулалттай	Авто замын инженер-3	Аль нэг авто замын инженер нь тухайн мэргэжлээрээ 15-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 10 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, Зөвлөх зэрэгтэй байх шаардлагатай.
	Гүүрийн инженер-1	Тухайн мэргэжлээрээ 15-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 8 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, Зөвлөх болон мэргэшсэн зэрэгтэй байх шаардлагатай.
	Геодезийн инженер-1	Тухайн мэргэжлээрээ 5 жилийн ажлын туршлагатай үүнээс 3 жилд нь замын зураг төсөл дээр геодезийн инженерээр ажилласан байх шаардлагатай. Хэмжилтийн багаж тоног төхөөрөмжийг чадварлаг эзэмшдэг байх. GPS болон топографын судалгаа, түүнтэй холбоотой программ хангамжийг мэргэжлийн тувшинд ашиглаж чаддаг байх.
	Хөдөлгөөн зохион байгуулалтын инженер-1	Тухайн мэргэжлээрээ 5-аас багагүй жил ажилласан ажлын туршлагатай байх. /Гэрээт байж болно/
	Төсөвчин-1	Тухайн мэргэжлээрээ 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 3 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх. Мөн замын зураг төслийн ажилд мэргэшсэн төсөвчнөөр ажилласан байх. /Энэ чиглэлээр 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай авто замын инженер байж болно./

Бүртгэлийн дугаар ... 400  
МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТӨСӨВРИЙН ХӨГЖЛИЙН ЯМ  
ХУУЛЬБАР ҮНЭН  
Хуульбар олгоссын дэхтэрээ төслийн цээж  
2009 он-д 07 арван 16 миний саар  
Он/Дэлхийн төслийн цээжийн  
ХХ ХУВЬ



Сандийн Төслийн цээжийн  
дэхтэрээ төслийн цээжийн  
ХХ ХУВЬ

авто замын зурвас газарт байгаа бусад байгууламжууд хамаарна/	Зургийн техникч - 3	Энэ чиглэлээр 3 жилийн ажлын туршлагатай, үүнээс 1 жилд нь замын хайгуул, зураг төсөл дээр ажилласан байх.
2.8.1.3. Хуримтлуулагч замын зураг төсөл боловсруулах /Замын байгууламжид б у/м-ээс ихгүй гүүр, гүүрэн гарц, хиймэл байгууламж авто замын хөдөлгөөнд зориулсан газар доогуурх гарц, хонгил, ус зайлцуулах шуудуу, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зориулалттай авто замын зурвас газарт байгаа бусад байгууламжууд хамаарна/	Авто замын инженер-2	Аль нэг инженер нь тухайн мэргэжлээрээ 10-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 8 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, Зөвлөх болон мэргэшсэн зэрэгтэй байх.
	Гүүрийн инженер-1	Тухайн мэргэжлээрээ 8-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 5 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, мэргэшсэн зэрэгтэй байх.
	Геодезийн инженер-1	Тухайн мэргэжлээрээ 5 жилийн ажлын туршлагатай үүнээс 3 жилд нь замын зураг төсөл дээр геодезийн инженерээр ажилласан байх шаардлагатай. Хэмжилтийн багаж, тоног төхөөрөмжийг чадварлаг эзэмшдэг байх. GPS болон топографын судалгаа, түүнтэй холбоотой программ хангамжийг мэргэжлийн түвшинд ашиглаж чаддаг байх.
	Төсөвчин-1	Тухайн мэргэжлээрээ 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 3 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх. Мөн замын зураг төслийн ажилд мэргэшсэн төсөвчнөөр ажилласан байх. /Энэ чиглэлээр 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай авто замын инженер байж болно./
	Зургийн техникч - 2	Энэ чиглэлээр 3 жилийн ажлын туршлагатай, үүнээс 2 жилд нь замын хайгуул, зураг төсөл дээр ажилласан байх.
2.8.1.4. Хотын авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах /Замын байгууламжид 30 у/м-ээс ихгүй гүүр, гүүрэн гарц, усны хоолой, авто замын хөдөлгөөнд зориулсан газар доогуурх гарц, хонгил, ус зайлцуулах	Авто замын инженер-2	Аль нэг инженер нь тухайн мэргэжлээрээ 15-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 8 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, Зөвлөх болон мэргэшсэн зэрэгтэй байх.
	Гүүрийн инженер-2	Аль нэг инженер нь тухайн мэргэжлээрээ 10-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 8 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, мэргэшсэн зэрэгтэй байх шаардлагатай.
	Геодезийн инженер-1	Тухайн мэргэжлээрээ 5 жилийн ажлын туршлагатай үүнээс 3 жилд нь замын зураг төсөл дээр геодезийн инженерээр ажилласан байх шаардлагатай. Хэмжилтийн багаж, тоног төхөөрөмжийг чадварлаг эзэмшдэг байх. GPS болон топографын судалгаа, түүнтэй холбоотой программ хангамжийг мэргэжлийн түвшинд ашиглаж чаддаг байх.
	Хөдөлгөөн зохион байгуулалтын инженер-1	Тухайн мэргэжлээрээ 3-аас багагүй жил ажилласан ажлын туршлагатай байх./Гэрээт байж болно/.



МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ ТЭЗВРИЙН ХӨРЖЛИМН ЯМ  
ХУУЛБАР ҮНЭН  
Хуулбар олгосон ажилтны төрчүүдэ  
20 дунд 07 сарын 16-ны өдөр

МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ ТЭЗВРИЙН ХӨРЖЛИМН ЯМ  
ХУУЛБАР ҮНЭН  
Хуулбар олгосон ажилтны төрчүүдэ  
20 дунд 07 сарын 16-ны өдөр

шуудуу, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зориулалттай авто замын зурвас газарт байгаа бусад байгууламжууд хамаарна./	Төсөвчин-1	Тухайн мэргэжлээрээ 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 3 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх. Мөн замын зураг төслийн ажилд Мэргэшсэн төсөвчнөөр ажилласан байх /энэ чиглэлээр 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай авто замын инженер байж болно./
	Зургийн техникч - 3	Энэ чиглэлээр 3 жилийн ажлын туршлагатай, үүнээс 1 жилд нь зураг төслийн ажилд ажилласан байх.
2.8.1.5. Хөдөө орон нутгийн замын зураг төсөл боловсруулах	Авто замын инженер-2	Аль нэг инженер нь тухайн мэргэжлээрээ 8-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 5 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, мэргэшсэн зэрэгтэй байх шаардлагатай
	Гүүрийн инженер-1	Аль нэг инженер нь тухайн мэргэжлээрээ 8-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 5 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, мэргэшсэн зэрэгтэй байх шаардлагатай
	Геодезийн инженер-1	Тухайн мэргэжлээрээ 5 жилийн ажлын туршлагатай үүнээс 3 жилд нь замын зураг төсөл дээр геодезийн инженерээр ажилласан байх шаардлагатай. Хэмжилтийн багаж, тоног төхөөрөмжийг чадварлаг эзэмшдэг байх. GPS болон топографын судалгаа, түүнтэй холбоотой программ хангамжийг мэргэжлийн түвшинд ашиглаж чаддаг байх.
	Төсөвчин-1	Тухайн мэргэжлээрээ 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 3 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх. Мөн замын зураг төслийн ажилд мэргэшсэн төсөвчнөөр ажилласан байх. /Энэ чиглэлээр 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай авто замын инженер байж болно./
	Зургийн техникч - 1	Энэ чиглэлээр 3 жилийн ажлын туршлагатай, үүнээс 1 жилд нь зураг төслийн ажилд ажилласан байх.
2.8.1.6. Нисэх буудлын хөөрч буух зурвасын зураг төсөл боловсруулах	Аэродромын инженер-1	Тухайн мэргэжлээрээ 10-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 8 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх.
	Авто замын инженер-1	Тухайн мэргэжлээрээ 10-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 8 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн мэргэшсэн инженер байх.
	Геодезийн инженер-1	Тухайн мэргэжлээрээ 8-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 6 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх.
	Төсөвчин-1	Тухайн мэргэжлээрээ 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 3 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх. Мөн замын зураг төслийн ажилд мэргэшсэн төсөвчнөөр ажилласан байх. /Энэ чиглэлээр 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай авто замын инженер байж болно./
	Зургийн техникч - 2	Энэ чиглэлээр 3 жилийн ажлын туршлагатай, үүнээс 2 жилд нь замын хайгуул, зураг төсөл дээр ажилласан байх.



2.8.1.7 Гүүр, туннелийн зураг төсөл боловсруулах	Гүүрийн инженер-2	Тухайн мэргэжлээрээ 15-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 10 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, аль нэг инженер нь Зөвлөх болон мэргэшсэн зэрэгтэй байх.
	Авто замын инженер - 1	Тухайн мэргэжлээрээ 6-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 5 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, мэргэшсэн зэрэгтэй байх шаардлагатай.
	Геодезийн инженер-1	Тухайн мэргэжлээрээ 5 жилийн ажлын туршлагатай үүнээс 3 жилд нь замын зураг төсөл дээр геодезийн инженерээр ажилласан байх шаардлагатай. Хэмжилтийн багаж, тоног төхөөрөмжийг чадварлаг эзэмшдэг байх. GPS болон топографын судалгаа, түүнтэй холбоотой программ хангамжийг мэргэжлийн түвшинд ашиглаж чаддаг байх.
	Төсөвчин-1	Тухайн мэргэжлээрээ 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 3 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх. Мөн замын зураг төслийн ажилд мэргэшсэн төсөвчнөөр ажилласан байх. /Энэ чиглэлээр 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай авто замын инженер байж болно./
	Зургийн техникч - 3	Энэ чиглэлээр 3 жилийн ажлын туршлагатай, үүнээс 2 жилд нь замын зураг төслийн ажилд ажилласан байх.
<b>Шаардлагатай тоног төхөөрөмж</b>		Компьютер, тоног төхөөрөмж, Програм хангамж, Нивелир, теодолит гэх мэт геодезийн хэмжилтийн багаж, хайгуулын ажлын машин, Стандарт норм дүрэм, төсвийн норм үнэлгээ, төсөв зохиох програм хангамжтай байх.



ХОЁР.Авто зам, замын байгууламжийг барих, засварлах, арчлах ажлын хүрээнд  
Нийтлэг нэхцэл шаардлага: Ажлын туршлагатай байх /хүснэгтэнд зааснаар/  
Ерөнхий нэхцэл шаардлага:

Д/Д	Нэрс ба хүчин чадал	Зөвшөөрөл авах ажлын төрөл		
		5 км хүртэл хатуу хучилттай зам барих	5 км-15 км хатуу хучилттай зам барих	15 км болон түүнээс дээш хатуу хучилттай зам барих
A.	<b>Зөвшөөрөл авахад шаардагдах технологийн зориулалттай машин механизм заасан тоогоор.</b>			
1	Экскаватор /0.65м <sup>3</sup> /	Түрээс байж болно.	1	2
2	Бульдозер /130м.х/	-	Түрээс байж болно.	1
3	Автогрейдер /250м.х/	1	1	2
4	Ачигч /1.0м <sup>3</sup> /	1	2	3
5	Доргиурт индүү /10 тн-оос дээш/	1	2	2
6	Хийн дугуйт индүү /20 тн/	Түрээс байж болно.	Түрээс байж болно.	1
7	Асфальтны индүү	Түрээс байж болно.	Түрээс байж болно.	1
8	Автогудронатор /3.5 м/	Түрээс байж болно.	Түрээс байж болно.	1
9	Өөрөө буулгагч	3	5	10
10	Усны машин /5 тн-оос дээш/	1	1	2
11	Асфальт дэвсэгч /7.0м-ээс багагүй/	Түрээс байж болно.	Түрээс байж болно.	Түрээс байж болно.
12	Авто Кран /25 тн-оос дээш/	Түрээс байж болно.	1	1
13	Шигшүүртэй чулуу бутлуур /60 тн/цаг/	-	Түрээс байж болно.	Түрээс байж болно.
14	Асфальтобетон завод /80 тн/цаг/	-	Түрээс байж болно.	Түрээс байж болно.
15	Лабораторийн бүрэн/	Түрээс байж болно.	Түрээс байж болно.	Түрээс байж болно.
16	Геодезийн иж бүрдэл	Түрээс байж болно.	Түрээс байж болно.	Түрээс байж болно.
<b>Зөвшөөрөл авахад шаардагдах мэргэжлийн ИТА-ын хамгийн бага тоогоор</b>				
18	Ерөнхий инженер	1	1	1
19	Авто замын инженер	1	2	2
20	Гүүр, хиймэл байгууламжийн инженер	-	-	1
21	Геодезийн инженер	1	1	1
22	Материалын инженер	1	1	2
B.	<b>Зэрэг дэвийн нэмэлт тайлбар</b>			
1.	Нэмэлт тайлбар:	Ерөнхий инженер нь 5 жилийн ажлын туршлагатай, мэргэшсэн инженер байх, Бусад заасан инженерүүд 1-3 жилийн ажлын туршлагатай байх,	Ерөнхий инженер нь 8 жилийн ажлын туршлагатай зөвлөх эсвэл мэргэшсэн зэрэгтэй байх, авто замын 1 инженер нь 5 жилийн ажлын туршлагатай байх, бусад заасан инженерүүд ажлын туршлагатай байх,	Ерөнхий инженер нь 8 жилийн ажлын туршлагатай зөвлөх буюу мэргэшсэн зэрэгтэй байх, Гүүр, хиймэл байгууламж, авто замын инженерүүд 5 жилийн ажлын туршлагатай аль нэг нь мэргэшсэн зэрэгтэй байх, бусад заасан инженерүүд 3-5 жилийн ажлын туршлагатай аль нэг инженер нь мэргэшсэн зэрэгтэй байх,

Бүртгэлийн дугаар ..... 400 .....



МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭЗРИЙН ХӨГЖЛИЙН ДАМ  
ХУУЛЬБАР ҮНСӨН  
Хуульбар олгоссон эжилтэй гарын ус

2010 оны 07 сарын 16-ний өдөр


МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭЗРИЙН ХӨГЖЛИЙН ДАМ  
ЭХ ХУВЬ

Төрийн наадмын цэцэрхэгийн  
дараалалын А/112

Д/Д	Нэрс ба хүчин чадал	Зөвшөөрөл авах ажлын төрөл		
		Хайрган хучилттай	Бүх төрлийн гүүр, тунель, газар доогуур нүхэн гарам барих	Зам барилга, засварын материал, хийцийн үйлдвэрлэл
A.	<b>Зөвшөөрөл авахад шаардагдах технологийн зориулалттай машин механизм заасан тоогоор.</b>			
1	Экскаватор /0.65м <sup>3</sup> /	Түрээс байж болно.	1	
2	Бульдозер /130м.х/	1	1	
3	Автогрейдер /250м.х/	1	Түрээс байж болно.	
4	Ачигч /1.0м <sup>3</sup> /	1	2	1
5	Доргиурт индүү /10 тн-оос дээш/	1	1	
6	Хийн дугуйт индүү /20 тн/			
7	Асфальтны индүү			
8	Автогудронатор /3.5 м/			
9	Өөрөө буулгагч	3 нь түрээс байж болно.	3	1
10	Усны машин /5 тн-оос дээш/	1	1	
11	Асфальт дэвсэгч /7.0м-ээс багагуй/			
12	Авто Кран /25 тн-оос дээш/		2	
13	Шигшүүртэй чулуу бутлуур /60 тн/цаг/	2		Түрээс байж болно.
14	Асфальтобетон завод /80 тн/цаг/			1
15	Лабораторийн бүрээн/	1	1	
16	Геодезийн иж бүрдэл	Түрээс байж болно.	1	
<b>Зөвшөөрөл авахад шаардагдах мэргэжлийн ИТА-ын хамгийн бага тоогоор</b>				
18	Ерөнхий инженер	1	1	
19	Авто замын инженер	1	1	1
20	Гүүр, хиймэл байгууламжийн инженер			
21	Геодезийн инженер	1	1	
22	Материалын инженер	1	1	2
B.	<b>Зэрэг дэвийн нэмэлт тайлбар</b>			
1.	Нэмэлт тайлбар:	Ерөнхий инженер нь 5 жилийн ажлын туршлагатай, мэргэшсэн инженер байх, Бусад заасан инженерүүд 1-3 жилийн ажлын туршлагатай байх,	Ерөнхий инженер нь ажлын туршлагатай мэргэшсэн инженер байх, Гүүрийн инженерийн нэг нь мэргэшсэн зэрэгтэй байх,	Материалын инженерийн нэг 3-5 жилийн ажлын туршлагатай мэргэшсэн инженер байх



Д/Д	Нэрс ба хүчин чадал	Зөвшөөрөл авах ажлын төрөл		
		Бүх төрлийн зам, гүүр, тунель, газар доогуур нүхэн гарам засварлах, замын байгууламжийн арчлалтын ажил	Зам, талбайн тохижилтийн ажил хийх, засварлах	Замын тоноглол, тэмдэг, тэмдэглэгээний ажил
A.	<b>Зөвшөөрөл авахад шаардагдах технологийн зориулалттай машин механизм заасан тоогоор.</b>			
1	Экскаватор /0.65м <sup>3</sup> /	1	Түрээсээр байж болно.	
2	Бульдозер /130м.х/			
3	Автогрейдер /250м.х/	2/1 нь түрээс байж болно/.	Түрээсээр байж болно.	
4	Ачигч /1.0м <sup>3</sup> /	1	Түрээсээр байж болно.	1
5	Доргиурт индүү /10 тн-оос дээш/		Түрээсээр байж болно.	
6	Хийн дугуйт индүү /20 тн/			
7	Асфальтны индүү			
8	Автогудронатор /3.5 м/			
9	Өөрөө буулгач			1
10	Усны машин /5 тн-оос дээш/			
11	Асфальт дэвсэгч /7.0м-ээс багагүй/	3		
12	Авто Кран /25 тн-оос дээш/	2 /1 түрээсээр байж болно/		
13	Шигшүүртэй чулуу бутлуур /60 тн/цаг/			Түрээс байж болно.
14	Асфальтобетон завод /80 тн/цаг/			1
15	Лаборатор/иж бүрэн/			
16	Геодезийн иж бүрдэл			
<b>Зөвшөөрөл авахад шаардагдах мэргэжлийн ИТА-ын хамгийн бага тоогоор</b>				
18	Ерөнхий инженер	1	1	
19	Авто замын инженер	1	1	1
20	Гүүр, хиймэл байгууламжийн инженер			
21	Геодезийн инженер	1	1	
22	Материалын инженер	1	1	2
B.	<b>Зэрэг дэвийн нэмэлт тайлбар</b>			
1.	Нэмэлт тайлбар:	Ерөнхий инженер нь 5 жилийн ажлын туршлагатай, мэргэшсэн инженер байх, Бусад заасан инженерүүд 1-3 жилийн ажлын туршлагатай байх,	Ерөнхий инженер нь ажлын туршлагатай мэргэшсэн инженер байх, Гүүрийн инженерийн нэг нь мэргэшсэн зэрэгтэй байх,	Материалын инженерийн нэг 3-5 жилийн ажлын туршлагатай мэргэшсэн инженер байх



МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ. ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯМ  
ХУУЛБАР ҮНӨН  
Хуулбар олгосон сийлтийн гаралт үсэг  
2020 оны 07 сарын 16-ны өдөр  
— 1 —  
ЭХ ХУВЬ

ГУРАВ. Техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлын хүрээнд:

2.8.3. Техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх	/Ерөнхий инженер/	Зам барилгын ажилд 10 жил, үүнээс 8-аас доошгүй жил зураг төслийн болон хяналтаар ажилласан, тэргүүн зэрэгтэй, зөвлөх болон мэргэшсэн инженер байх /Гэрээгээр байж болно/.
	Замын инженер-2	Зам барилгын 10 жил, чиглэлээр 5 жил 3-аас доошгүй жил хяналтанд ажилласан, замын инженерийн мэргэжилтэй байх. Аль нэг инженер нь мэргэшсэн, ахлах инженерийн зэрэгтэй байх.
	Гүүрийн инженер-1	Зам барилгын чиглэлээр 5 жил, үүнээс 3-аас доошгүй жил хяналтанд ажилласан, гүүрийн инженерийн мэргэжилтэй, мэргэшсэн, ахлах инженерийн зэрэгтэй байх эсвэл дээрхи шаардлагыг хангасан барилгын материалын инженер мэргэшсэн, ахлах инженер байх.
	Материалын инженер-2	Тухайн чиглэлээр 5 жил, үүнээс 3-аас доошгүй жил хяналтаар ажилласан, хяналтын ажлын туршлагатай, зам, гүүрийн инженерийн мэргэжилтэй мэргэшсэн, ахлах инженерийн зэрэгтэй байх эсвэл дээрхи шаардлагыг хангасан барилгын материалын инженер мэргэшсэн, ахлах инженер байх.
	Тоо хэмжээний инженер-1	Тухайн чиглэлээр 5 жил, үүнээс 3-аас доошгүй жил хяналтанд ажилласан, хяналтын ажлын туршлагатай, зам, гүүрийн инженерийн мэргэжилтэй, мэргэшсэн төсөвчин, инженер байх.
	Хэмжилтийн инженер-1	Тухайн чиглэлээр 5 жил, үүнээс 3-аас доошгүй жил хяналтанд ажилласан, хяналтын ажлын туршлагатай, зам, гүүрийн инженер, мэргэшсэн, ахлах инженерийн зэрэгтэй байх эсвэл геодезийн инженер мэргэшсэн, ахлах инженерийн зэрэгтэй байх.
<b>Шаардлагатай тоног төхөөрөмж</b>		Компьютер, тоног төхөөрөмж, Програм хангамж, Нивелир, теодолит гэх мэт геодезийн хэмжилтийн багаж, хайгуулын ажлын машин, Стандарт норм дүрэм, төсвийн норм үнэлгээ, төсөв зохиох програм хангамжтай байх.

- ИТА-ын нийгмийн даатгалын дэвтрийг хуулбарлаж, нотариатаар баталгаажуулан өргөдөл хавсаргах.
- Баталгаажсан нийгмийн даатгалын тайланг НД-7, НД-8 маягтын дагуу ирүүлэх.
- Диплом болон техникийн гэрчилгээ, жолооны үнэмлэх болон бусад нотлох баримтын хувийг нотариатаар баталгаажуулан хавсаргах.

----оОо----

Бүртгэлийн дуглас ... 400 ...
МОНГОЛ УЛСЫН
ЗАМ. ТЭЭЗБРИЙН ХӨРЖЛИЙН ГАМ*
ХУУЛБАР ҮНЭТ
Хуулбар олон улсын дэд засгийн төслийн улсын Онцгойлжилж буй нийтийн төслийн хуулбарын 20 07 сарын 16
ЗАМ. ТЭЭЗБРИЙН ХӨРЖЛИЙН ГАМ*
ЗХ ХУВЬ
Сандийн Ториин нарийн бичигийн дараалж буй нийтийн төслийн хуулбарын 20 07 сарын 16